

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн үр дүнгээр урамшуулал
олгох журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт, Эрчим хүчний салбарын 2015-2016 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.3, 38.3.4 дэх заалт, “Амгалан дулааны станц” ХХК-ийн Захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд 2017-2018 оны хооронд хэрэгжүүлэхээр байгуулсан хамтын гэрээний 3.4А, 3.4.Б дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Амгалан дулааны станц” ХХК-ийн “Үйлдвэрлэлийн үр дүнгээр урамшуулал олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, алба, цех, хэлтэс, хэсгийн ажил дүгнэх үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар, жилийн ажлын үр дүнгээр урамшуулал олгох үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйлдвэрлэлийн үр дүнгээр урамшуулал олгох журам, алба, цех, хэлтэс, хэсгийн ажил дүгнэх үзүүлэлт, жилийн ажлын үр дүнгээр урамшуулал олгох үзүүлэлтийг 2018 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус мөрдсүгэй.


3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Амгалан дулааны станц” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны А/53 дугаар тушаалуудыг энэхүү тушаал хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүйд тооцсугай.

4.Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ган-очирт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ХХК-ИЙН АЖИЛТНУУДАД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮР ДҮНГЭЭР УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, осол, аварь, гал түймрийн осолгүй ажиллуулах, тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээний чанар, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд ажилтан нэг бүрийн идэвхи санаачилга, урам зоригийг өрнүүлэхэд энэхүү журмын зорилго чиглэгдэнэ.

НЭГ. САРЫН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР УРАМШУУЛАЛ ОЛГОХ

1.1. Сарын ажлын үр дүнгээр урамшуулал олгох нөхцөл

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад дараах хүчин зүйлийг хангасан тохиолдолд сарын үр дүнгийн урамшуулал олгоно.

1. Тухайн сарын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө биелэгдсэн нөхцөлд үйлдвэрлэлийн үр дүнгээр урамшуулал олгох нөхцөл бүрдэх ба биелэлтийг тооцохдоо үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохгүй.
2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь эрсэдсэн хүнд бүлэг осол гараагүй бол,
3. Станцыг бүрэн зогсоосон аваар, их хэмжээний хөрөнгө шатсан гал түймэр гараагүй бол,
4. Гадны байгууллага болон хувь хүн, давагдашгүй хүчин зүйлээс хамаарч 1-3 дахь заалтууд үүссэн бол,

Сарын үр дүнгийн урамшуулал олгох хувь хэмжээг тогтооходоо үйлдвэрлэл явагдсан үе, үйлдвэрлэл явагдаагүй үе гэсэн 2 хэлбэрээр дүгнэж Амгалан дулааны станцын Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна. Үүнд:

А. Үйлдвэрлэл явагдсан сарын үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг тогтоох үзүүлэлт:

Хүснэгт № 1

№	Үзүүлэлт	Хэмж их нэгж	ҮСТөлөвл өгөө	Гүйцэт гэл	Олговол зохих хувь	Олгосо н хувь	Хувь тогтоосон удирдлага
1	Түгээсэн ДЭХ- ний сарын төлөвлөгөө биелсэн бол /Сарын төлөвлөгөө биелээгүй боловч ДҮТ-өөс өгсөн параметрийн горим биелсэн бол/	Гкал			20%		Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер
2	Өссөн дүнгээр төлөвлөгөөт	Мян. төг			10%		Санхүү эрхэлсэн

	алдагдлыг хэтрүүлээгүй бол						Захирал
3	Технологийн зөрчил болон хөнгөн осол, зөрчил гараагүй бол	Тоо			10%		ХАБЭА-н инженер
Дүн /хувиар/					40%		Гүйцэтгэх захирал

Б. Үйлдвэрлэлийн сул зогсолтын үед үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг тогтоох үзүүлэлт:

Хүснэгт № 2

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	ҮСТөлөв лөгөө	Гүйцэтг эл	Олговол зохих хувь	Олгос он хувь	Хувь тогтоосон удирдлага
1	Байгууллагын сарын ажлын төлөвлөгөөний биелэлт	тоо			10%		Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
2	Их болон урсгал засварын графикийн биелэлт	Мян.төг			10%		Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер
3	Сарын дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол	Мян.төг			10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
4	Хөнгөн осол, зөрчил гаргаагүй бол	тоо			10%		ХАБЭА-н инженер
Дүн /хувиар/					40%		Гүйцэтгэх захирал

Жич: Тухайн сард үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь эрсэдсэн хүнд бүлэг осол гарсан, станцыг бүрэн зогсоосон аваар, их хэмжээний хөрөнгө шатсан гал түймэр гарсан бол ХАБЭАИнженер, ГАБХАЖилтан нар тогтоосон актаа Захиргаа, удирдлагын хэлтэст ирүүлж тухай сарын үр дүнгийн урамшууллыг зогсоох шийдвэр гаргуулна.

1. Сарын ажлын үр дүнгээр олгох урамшууллын дээд хувь хэмжээг ажилтны төлөөлөлтэй байгуулсан хамтын гэрээнд заагдсанаар тооцно.
2. Тухайн сард үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь эрсэдсэн хүнд бүлэг осол гарсан, станцыг бүрэн зогсоосон аваар, их хэмжээний хөрөнгө шатсан гал түймэр гарсан бол ХАБЭАИнженер, ГАБХАжилтан нар дараа сарын 15-ны дотор тогтоосон актаа Захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлнэ.
3. Түгээсэн ДЭХ-ний сарын төлөвлөгөөний биелэлт /ДҮТ-өөс өгсөн сарын төлөвлөгөөнд оруулсан графикайн биелэлт/-ийг Горимын хяналт, тооцооны инженер нь дараа сарын 15-ны дотор Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлнэ. /Хүснэгт № 1, 2/
4. Үйлдвэрлэлийн үед төлөвлөгөөт ашиг, алдагдлыг өссөн дүнгээр, үйлдвэрлэлийн сул зогсолтын үед төлөвлөгөөт зардлын биелэлтийг Санхүү эдийн засгийн хэлтэс нь дараа сарын 15-ны дотор Гүйцэтгэх захирлаар батлуулна. /Хүснэгт № 1, 2/
5. Алба, хэлтэс, цех, хэсгийн сарын үр дүнгийн урамшууллыг хавсралтанд заагдсан үзүүлэлтээр дүгнэнэ.
6. Дүгнэгдсэн үр дүнгийн урамшууллын хуудсыг Захиргаа удирдлагын хэлтэс нь Санхүү эдийн засгийн хэлтэст дараа сарын 20-ний дотор хүргүүлнэ.
7. Ажилтнуудын үр дүнгийн урамшууллыг хариуцсан алба, хэлтэс, цех, хэсгийн дарга нарын дүгнэсний дагуу тооцон, сар бүрийн цалингийн хамт олгоно.

1.3. Алба, хэлтэс, цех, хэсгийн удирдлагын эрх, үүрэг

1. Алба, хэлтэс, цех, хэсгийн удирдлагууд нь ажилтнуудынхаа идэвхи зүтгэл, ажлын үр дүнг батлагдсан үзүүлэлтийн дагуу дүгнэж, урамшууллын хувь хэмжээг тогтоохдоо Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан хувь хэмжээнээс хэтрүүлж болохгүй.
2. Ажилтан нэг бүрийг хариуцсан алба, хэлтэс, цехийн удирдлагууд нь дүгнэж Гүйцэтгэх захирлаар батлуулсан байна. Сарын үр дүнгийн урамшуулал дүгнэсэн хуудсыг Санхүү эдийн засгийн хэлтэст дараа сарын 25-ний дотор хүргүүлнэ. Дүгнэх хуудсыг хүргүүлэх хугацааг хоцроосон нэгжийн сарын үр дүнгийн урамшууллыг тухайн сард нь олгохгүй.
3. Хариуцсан ажилдаа зөрчил, доголдол гаргасан, компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй техникийн болон захиргааны бодлого, шийдвэрүүд, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн, ажлын үр бүтээл муутай ажилласан, хурал, сонсгол, олон нийтийн арга хэмжээнд оролцоогүй, ирсэн боловч идэвхгүй ажилласан буюу ирээд зөрчил гаргасан ажилтны урамшууллыг бууруулах буюу олгохгүй байж болно.
4. Доор дурьдсан тохиолдолд сарын үр дүнгийн урамшуулал олгогдохгүй. Үүнд:
 - 4.1 Гүйцэтгэх захирлын тушаалаар арга хэмжээ авагдсан тухайн сард,
 - 4.2 Үндсэн цалинг хааж гэрээт ажилд орсон буюу суралцахаар ажлаас чөлөөлөгдсөн хугацаанд,
 - 4.3 Хөдөлмөрийн тухай хуулийн 23.2.3 дугаар зүйлийн дагуу дагалдан ажилтан болон туршилтын хугацаагаар ажиллаж буй ажилтанд,
 5. Монгол Улсын Үйлдвэрчний эвлэлүүдийн тухай хууль, компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээг үндэслэн Үйлдвэрчний эвлэлийн хорооны орон тооны ажилтанг энэхүү журамд заасан урамшуулалд хамруулна. ҮЭ-ийн хорооны орон

урамшууллын дундаж хувиар тогтоон олгоно.
5.1 Үйлдвэрчний эвлэлийн орон тооны ажилтанд дараах тохиолдолд сарын үр дүнгийн урамшуулал олгохгүй. Үүнд:

- 5.1.1 Үйлдвэрлэлийн сул зогсолтын хугацаанд сарын үр дүнгийн урамшуулал тооцон олгохгүй.
- 5.1.2 Өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, ажил тасалсан хугацаанд сарын үр дүнгийн урамшуулал тооцон олгохгүй.
- 5.1.3 Гэрээт ажилд орсон буюу суралцахаар ажлаас чөлөөлөгдсөн хугацаанд,

ХОЁР. ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР УРАМШУУЛАЛ ОЛГОХ НӨХЦӨЛ

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад дараах хүчин зүйлийг хангасан тохиолдолд жилийн үр дүнгийн урамшууллыг 5 хүртэл сарын албан тушаалын ба тарифт цалингийн хэмжээгээр олгоно.
 1. Тухайн жилийн үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө биелэгдсэн нөхцөлд үйлдвэрлэлийн үр дүнгээр урамшуулал олгох нөхцөл бүрдэх ба биелэлтийг тооцохдоо үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохгүй.
 2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь эрсэдсэн хүнд бүлэг осол гараагүй бол,
 3. Станцыг бүрэн зогсоосон аваар, их хэмжээний хөрөнгө шатсан гал түймэр гараагүй бол,
 4. Гадны байгууллага болон хувь хүн, давагдашгүй хүчин зүйлээс хамаарч 1-3 дахь заалтууд үүссэн бол,
2. Дээд шатны байгууллага болон харилцагч байгууллагын шийдвэрээс хамаарч тухайн жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө биелээгүй тохиолдолд ДҮТ-өөс өгсөн параметрийн горимын биелэлтээр дүгнэж олгоно.
3. Компанийн тайлан хамгааллуулах комиссын үнэлгээний дүнг үндэслэн алба, хэлтэс, цех, хэсгийн жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг тогтооно.
4. Урамшуулал олгох цалингийн дундажийг тодорхойлохдоо үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан хугацаанд тухайн ажилтанд олгосон албан тушаалын буюу тарифт цалинг үндэслэн тооцно. Ажилтны төрөхийн өмнөх болон төрсний дараах эмнэлэгийн чөлөөтэй хугацааг тухайн жилд ажилласан хугацаанд тооцно.
5. Компанийн хэмжээнд жилийн үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг тогтоохдоо энэхүү журмын гуравдугаар хавсралт хүснэгт №13-ийг дүгнэхээс ажлын 5 хоногийн өмнө холбогдох албан тушаалтнууд дүгнэж Захиргаа, удирдлагын хэлтэст ирүүлсэн байна.
6. Доор дурьдсан тохиолдолд жилийн үр дүнгээр урамшуулал бууруулах буюу олгохгүй. Үүнд:
 - 6.1 Захиргаанаас сануулах арга хэмжээ авагдсан бол урамшууллыг 20%-иар, цалин бууруулах арга хэмжээ авагдсан бол урамшууллыг 40%-иар, ажлаас халагдсан бол 100%-иар тус тус бууруулан тооцно.
 - 6.2 Компанид тухайн жилд ажилласан хугацаа нь 6 сар хүрээгүй. /хүүхэд асрах чөлөөнөөс ажилд орсон эцэг, эхчүүдэд хамаарахгүй/

**ГУРАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГУУДАД САРЫН БОЛОН ЖИЛИЙН
АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЗАРЧИМ**

1. Гүйцэтгэх захиралд олгох жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тогтоосон хувь хэмжээгээр олгоно.
2. Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Дэд захирал нарын сарын болон жилийн үр дүнгээр олгох урамшууллын хувь хэмжээг Гүйцэтгэх захирал тогтооно.
3. Алба, хэлтэс, цехийн дарга нарт олгох сарын урамшууллын хувь хэмжээг Хүснэгт №12-ийн дагуу дүгнэн олгоно.



БАТЛАВ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ

I. Зуухан цехийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 3

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	ДЭХ-ний төлөвлөгөөний горим ажиллагааг хангаж ажилласан бол,	10%		Ерөнхий инженер
2	ААД, ТАД- ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ХАБЭАИ
3	ХАБЭА-н I, II шатны үзлэгийг хугацаанд нь хийж, зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	10%		ХАБЭАИ
4	Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан зуух болон үндсэн тоноглолын төлөвлөгөөт бус зогсолт гаргаагүй бол,	15%		ХАБЭАИ
5	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
6	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
7	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
8	Тоноглолыг графикийн дагуу ажиллагаанд болон бэлтгэлд бэлэн байлгасан бол,	10%		Ерөнхий инженер
9	Гэмтлийг шуурхай, чанартай устгасан бол,	10%		Ерөнхий инженер
10	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
11	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
12	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан бол,	5%		ЭХХ-ийн менежер
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА:

II. Түлш дамжуулах цехийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 4

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Зуухыг чанарын шаардлага хангасан нүүрсээр тасралтгүй хангасан бол,	10%		Ерөнхий инженер
2	ААД, ТАД- ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ХАБЭАИ
3	ХАБЭА-н I, II шатны үзлэгийг хугацаанд нь хийж, зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	10%		ХАБЭАИ
4	Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үндсэн ба туслах тоноглолын төлөвлөгөөт бус зогсолт гаргаагүй бол,	15%		ХАБЭАИ
5	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
6	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
7	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
8	Тоноглолыг графикийн дагуу ажиллагаанд болон бэлтгэлд бэлэн байлгасан бол,	10%		Ерөнхий инженер
9	Гэмтлийг шуурхай, чанартай устгасан бол,	10%		Ерөнхий инженер
10	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
11	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
12	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан бол,	5%		ЭХХ-ийн менежер
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН ДАРГА:

III. Нэгдсэн цехийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 5

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Технологийн усны горим, цахилгаан тоноглол, дулааны хянах, хэмжих хэрэгсэл, технологийн удирдлагын системийн хэвийн ажиллагааг хангасан бол,	10%		Ерөнхий инженер
2	ААД, ТАД- ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ХАБЭАИ
3	ХАБЭА-н I, II шатны үзлэгийг хугацаанд нь хийж, зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	10%		ХАБЭАИ
4	Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан тоноглолын төлөвлөгөөт бус зогсолт гаргаагүй бол,	15%		ХАБЭАИ
5	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
6	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
7	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
8	Тоноглолыг графикийн дагуу ажиллагаанд болон бэлтгэлд бэлэн байлгасан бол,	10%		Ерөнхий инженер
9	Гэмтлийг шуурхай, чанартай устгасан бол,	10%		Ерөнхий инженер
10	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
11	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
12	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан бол,	5%		ЭХХ-ийн менежер
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: НЭГДСЭН ЦЕХИЙН ДАРГА:

IV. Ээлжийн инженерийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 6

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	1-р ээлжийн инженер	2-р ээлжийн инженер	3-р ээлжийн инженер	4-р ээлжийн инженер	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Ээлжиндээ ДҮТ-ээс өгсөн горимыг барьж, зөрчилгүй ажилласан бол,	10%					Ерөнхий инженер
2	Нүүрсний зарцуулалт, ус, цахилгаан, дулааны тооцоог тухай бүрт тооцоолсон бол,	10%					Ерөнхий инженер
3	ААД, ТАД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%					ХАБЭАИ
4	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%					ГАБСХА
5	ХАБЭА-н I, II шатны үзлэгийг хугацаанд нь хийж, зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	15%					ХАБЭАИ
6	Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан тоноглолын төлөвлөгөөт бус зогсолт гаргаагүй бол,	15%					ХАБЭАИ
7	Тоноглолд гарсан гэмтлийг шуурхай, чанартай устгуулах ажиллагаанд хяналт тавьж хугацаанд нь хийлгүүлсэн бол,	10%					Ерөнхий инженер
8	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, “Хөдөлмөрийн дотоод журам” бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%					ЗУХ-ийн дарга
9	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%					ЗУХ-ийн дарга
10	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	10%					Санхүү эрхэлсэн дэд захирал
Дүн		100%					

ТАНИЛЦСАН: ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР:

V. Хяналтын хэсгийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 7

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг даалгавар биелүүлсэн бол,	10%		Гүйцэтгэх захирал
2	Хяналт шалгалтын сарын төлөвлөгөө биелсэн бол,	10%		Гүйцэтгэх захирал
3	ААД, ТАД-ын зөрчлүүдийг илрүүлэх, зөрчлийн 90-ээс доошгүй хувийг нь арилгуулсан бол,	15%		Гүйцэтгэх захирал
4	ГАУСД-ийн зөрчлүүдийг илрүүлэх, зөрчлийн 90-ээс доошгүй хувийг арилгуулсан бол,	10%		Гүйцэтгэх захирал
5	Даралтат сав, шугам хоолойн ашиглалт, сорил шалгалтын графикийг мөрдүүлэх, илрүүлсэн зөрчлийн 90-ээс доошгүй хувийг арилгуулсан бол,	10%		Гүйцэтгэх захирал
6	Дотоод аудитын сарын төлөвлөгөөт үзлэг шалгалтаар илрүүлсэн зөрчлийн 90-ээс доошгүй хувийг арилгуулсан бол,	10%		Гүйцэтгэх захирал
7	ХАБЭА-н II, III шатны үзлэгийн зөрчлийг хугацаанд нь арилгуулсан бол,	10%		Гүйцэтгэх захирал
8	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
9	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
10	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
11	Шилэн дансны мэдээлэлд хяналт тавьсан байдал	5%		ЗУХ-ийн дарга
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: ДОТООД АУДИТОР:

VI. Авто, машин механизмын хэсгийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 8

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Авто машин механизмын бэлэн байдлыг хангасан бол,	10%		Ерөнхий инженер
2	Авто машин механизмын засвар үйлчилгээг графикт хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн бол,	10%		Дэд захирал
3	ЗХД, ЗХАБТХууль, ААД, ТАД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ХАБЭАИ
4	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
5	ХАБЭА-н I, II шатны үзлэгийн зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	15%		ХАБЭАИ
6	Наряд, зааварчилгааг тухай бүр бүрэн өгч, бүртгэл хөтөлсөн бол,	10%		ХАБЭАИ
7	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
8	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
9	Гарсан эвдрэл гэмтлийг шуурхай, чанартай устгасан бол,	10%		Дэд захирал
10	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
11	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: АВТЫН ИНЖЕНЕР:

VII. Аж ахуй хангамжийн албаны ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 9

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Тохижилт, үйлчилгээний ажлын чанар сайн хийгдсэн бол,	10%		ЗУХ-ийн дарга
2	Худалдан авах төлөвлөгөөний биелэлт	10%		Дотоод аудит
3	Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт	5%		Ерөнхий инженер
4	Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь өгсөн бол,	10%		Дотоод аудитор
5	Тухайн сард чанарын шаардлага хангасан сэлбэг материалаар хугацаанд нь хангасан бол,	10%		Дотоод аудитор
6	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
7	ХАБЭА-н I, II шатны үзлэгийн зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	10%		ХАБЭАИ
8	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
9	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
10	Харуул хамгаалалтын үүргийн биелэлт сайн бол,	10%		Дэд захирал
11	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
12	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: АЛБАНЫ ДАРГА:

VIII. Захиргаа Удирдлагын хэлтсийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 10

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Байгууллагын сарын ажлын төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гүйцэтгүүлсэн бол,	10%		Гүйцэтгэх захирал
2	Шилэн дансны мэдээлэл хугацаанд нь оруулсан бол,	10%		Дотоод аудитор
3	Мэдээ, тайланг хугацаанд нь гаргасан бол,	10%		Дотоод аудитор
4	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
5	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
6	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		Гүйцэтгэх захирал
7	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		Гүйцэтгэх захирал
8	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
9	ХАБЭА-н I, II шатны үзлэгийн зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	15%		ХАБЭАИ
10	Компанийн ажилтнуудын ажлын цаг ашиглалтын түвшинг бууруулаагүй бол,	10%		Гүйцэтгэх захирал
11	Төлөвлөгөөт сургалтыг хугацаанд нь зохион байгуулсан бол,	10%		Гүйцэтгэх захирал
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА:

IX. Санхүү эдийн засгийн хэлтсийн ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 11

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай мөнгөн хөрөнгө бэлэн байлгасан бол,	15%		Санхүү эрхэлсэн дэд захирал
2	Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь өгсөн бол,	5%		Дотоод аудитор
3	Мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлсэн бол,	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
4	Жил, улирал, сарын төлөвлөгөөг хугацаанд нь үнэн бодитоор гаргасан бол,	10%		Дотоод аудитор
5	Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтад хяналт тавьсан байдал	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
6	Өссөн дүнгээр төлөвлөгөөт зардлыг хэтрүүлээгүй бол,	10%		Санхүү эрхэлсэн дэд захирал
7	Өмч хөрөнгийн ашиглалт, зардлын зөрчилгүй бол,	5%		Санхүү эрхэлсэн дэд захирал
8	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгавар, компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
9	Цаг ашиглалт, ирц зөрчилгүй бол,	5%		ЗУХ-ийн дарга
10	ГАУСД-ийн зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
11	ХАБЭА-н I, II шатны үзлэгийн зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	15%		ХАБЭАИ
Дүн		100%		

ТАНИЛЦСАН: САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА:

X. Цех, алба, хэлтсийн даргын ажил дүгнэх үзүүлэлт

Хүснэгт № 12

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Хувь тогтоосон албан тушаалтны гарын үсэг
1	Алба, хэлтэс, цехийн төлөвлөгөөний биелэлт 90-ээс дээш хувийн биелэлттэй бол,	10%		Шууд удирдлага
2	Удирдлага, захиргаанаас өгөгдсөн үүрэг, албан даалгаварыг хугацаанд нь биелүүлсэн бол,	10%		Шууд удирдлага
3	Хариуцсан алба, хэлтэс, цех нь ААД, ТАД-ын зөрчил гаргаагүй бол,	15%		ХАБЭАИ
4	Хариуцсан алба, хэлтэс, цех нь ГАУСД-ын зөрчил гаргаагүй бол,	10%		ГАБХА
5	Хариуцсан алба, хэлтэс, цех нь ХАБЭА-н III шатны үзлэгийн зөрчлийг хугацаанд нь арилгасан бол,	10%		ХАБЭАИ
6	Ажилтнуудын техник, технологийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд санаачлагатай ажилласан бол,	10%		Шууд удирдлага
7	Цаг ашиглалт, ажлын ирц, шуурхай зөвлөлгөөний ирцийн зөрчилгүй бол,	10%		Шууд удирдлага
8	Компаний "Хөдөлмөрийн дотоод журам" бусад журам, заавруудын хэрэгжилт зөрчилгүй бол,	10%		Шууд удирдлага
9	Өөрийн эрхэлсэн ажлын чиглэлээр удирдлагуудыг мэдээ, тайлан, мэдээллээр тасралтгүй хангаж ажилласан бол,	15%		Шууд удирдлага
Дун		100%		

ТАНИЛЦСАН: АЛБА, ХЭЛТЭС, ЦЕХ, ХЭСГИЙН ДАРГА:



Амгалан дулааны станц ХХК-ийн
 Гүйцэтгэх захирлын 2018 оны 06 сарын 01-ний
 өдрийн /50/ дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫН АЖИЛТНУУДАД ОНЫ ЖИЛИЙН
 АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР УРАМШУУЛАЛ ОЛГОХ ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт № 13

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	Зорилтот оны			Жилийн үр дүнгийн урамшуулал	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/	Олговол зохих сар	Олгосон сар
1	ДЭХ-ний төлөвлөгөөний биелэлт	Гкал						
2	Ашгийг нэмэгдүүлж, төлөвлөгөөт зардлыг бууруулсан байдал	Сая.төг						
3	ДЭХ-ний борлуулалтын орлогын төлөвлөгөөний биелэлт	Сая.төг						
4	Жишмэл түлшний хувийн зарцуулалтыг бууруулсан байдал	Кг/Гкал						
5	Технологийн зөрчлийг өмнөх оноос бууруулсан байдал	Тоо						
ДҮН								